



Цахилгаан эрчим хүчээр хангах , хэрэглэх
аж ахуйн гэрээ

2015.02.18

Хэрлэн сум

Нэг талаас: Хангагчийг төлөөлж / цаашид хангагч гэх / ' Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем ' хувьцаат компаний гүйцэтгэх захирал Ч.Чинбат

Нөгөө талаас: Хэрэглэгчийг төлөөлж / цаашид хэрэглэгч гэх / 'Дорнод Радио Телевизийн станц"-ийн дарга Н.Сайнбаяр " Эрчим хүчний тухай Монгол улсын хууль", "Иргэний хууль" , "Цахилгаан эрчим хүч ашиглах дүрэм", "Аж ахуйн харилцааны дүрэм" зэрэгт үндэслэн харилцан тохиролцсоны дагуу энэхүү гэрээг дор дурьдсан нөхцлөөр байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Хангагч ба хэрэглэгч талууд аж ахуйн үйл ажиллагаандаа өөрсдийн хүлээсэн үүргээ биелүүлэх болон төлбөр тооцооны асуудлыг шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах, хоёр талын эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлоход энэхүү гэрээний зорилго оршино.

1.2 Хангагч болон хэрэглэгч талууд үйл ажиллагаандаа ' Эрчим хүчний тухай Монгол улсын хууль ' , " Иргэний хууль " , Цахилгаан эрчим хүч ашиглах дүрэм', ' Аж ахуйн харилцааны дүрэм ' болон энэ гэрээний заалтуудыг удирдлага болгон ажиллана.

1.3 Монгол улсын хууль журмын дагуу засвар үйлчилгээний стандартад аливаа өөрчлөлт орсон тохиолдолд цаг тухайд нь гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж байх.

Хоёр. Хангагчийн эрх, үүрэг

Цахилгаан эрчим хүчний хангагч нь ' Эрчим хүчний тухай Монгол улсын хууль '-д зааснаар дараах эрх, үүрэгтэй.

2.1 Цахилгаан эрчим хүчээр хангах үйл ажиллагаандаа тусгай зөвшөөрөлтэй байх бөгөөд тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхгүй. Хангагч нь цахилгаан дамжуулах шугам болон цахилгаан эрчим хүчний хангамжийг харъяалан захирах эрхтэй байх бөгөөд холбогдох талуудтай харилцах харилцааг зохицуулах асуудалыг хариуцна.

2.2 2015 оны 03 дүгээр сарын 01-ны өдрөөс 2016 оны 03 дүгээр сарын 01-ны өдрийг хүртэл стандартын шаардлагад нийцсэн цахилгаан эрчим хүчээр хангах.